# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Соёлын төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/188/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Гурван Хөх Морьт Аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг
Утас: 99051815 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com

Аудитор: Д.Соёлсайхан
Утас: 91929196 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/260

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
Н.БАТПҮРЭВ ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Мөнгөн хөрөнгө данс өмнөх оноос 26,940.9 төгрөгөөр буурсан нь төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тайлант онд төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой бууралт байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 30,218.2 мянган төгрөгийн 6 зөрчилд 6 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Соёлын төвийн дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **55,842,911.56** | **27,763,856.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 26,940,955.56 | - |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 26,940,955.56 | - |
| **3121** | **Төгрөг** | 26,940,955.56 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 26,940,955.56 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 28,901,956.00 | 27,763,856.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,901,956.00 | 27,763,856.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 51,350.00 | 183,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,971,106.00 | 9,628,856.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 10,500,000.00 | 17,150,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 10,379,500.00 | 452,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 350,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **608,192,453.72** | **622,903,825.76** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 608,192,453.72 | 622,903,825.76 |
| **392** | **Биет хөрөнгө** | 596,282,953.68 | 611,385,325.68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 581,916,300.00 | 581,916,300.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (49,280,525.40) | (59,136,630.48) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 41,872,873.00 | 67,016,468.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,128,503.78) | (30,359,184.54) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,117,592.40 | 28,498,882.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,169,772.74) | (19,987,343.18) |
| 39213 | Түүх соёл, музейн  дурсгалт зүйлс | 16,937,500.00 | 16,937,500.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 18,507,000.00 | 18,552,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,815,783.80) | (4,378,940.52) |
| 39217 | Ном | 11,326,274.00 | 12,326,274.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,909,500.04 | 11,518,500.08 |
| 39301 | Программ хангамж | 1,630,000.00 | 1,630,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (462,499.96) | (853,499.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,742,000.00 | 10,742,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **664,035,365.28** | **650,667,681.76** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **300,000.00** | **714,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 300,000.00 | 714,000.00 |
| **413** | **Өглөг** | 300,000.00 | 714,000.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 300,000.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | - | 714,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 714,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **663,735,365.28** | **649,953,681.76** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 663,735,365.28 | 649,953,681.76 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 295,141,730.30 | 295,141,730.30 |
| 51101 | Өмч:  - төрийн | 295,141,730.30 | 295,141,730.30 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 341,138,535.80 | 327,356,852.28 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 309,584,623.60 | 341,138,535.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 31,553,912.20 | (13,781,683.52) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 27,455,099.18 | 27,455,099.18 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **664,035,365.28** | **650,667,681.76** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **245,254,975.7** | **385,011,712.7** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **21,970,000.0** | **31,118,582.0** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 21,970,000.0 | 31,118,582.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,370,000.0 | 1,800,000.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 760,000.0 | 1,800,000.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 610,000.0 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 20,600,000.0 | 29,318,582.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **223,284,975.7** | **353,893,130.7** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 190,598,675.7 | 304,724,530.7 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 190,598,675.7 | 304,724,530.7 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,686,300.0 | 49,168,600.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,686,300.0 | 49,168,600.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **213,701,063.5** | **387,925,660.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **213,701,063.5** | **387,925,660.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 204,221,025.5 | 321,136,317.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 125,764,054.0 | 213,792,698.8 |
| 210101 | Үндсэн цалин | 97,298,210.1 | 133,581,475.5 |
| 210102 | Нэмэгдэл | 15,019,595.2 | 61,353,003.6 |
| 210104 | Урамшуулал | 13,446,248.8 | 18,858,219.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 15,361,741.8 | 27,005,379.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,660,245.9 | 18,190,392.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,227,288.9 | 2,068,338.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,097,077.9 | 1,356,541.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 222,418.7 | 1,132,842.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,154,710.5 | 4,257,264.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,086,262.0 | 18,016,734.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,984,862.0 | 2,616,734.9 |
| 210302 | Түлш, халаалт | 25,101,400.0 | 15,400,000.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,294,274.3 | 16,906,400.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 380,850.0 | 737,050.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,780,500.0 | 8,824,300.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 551,774.3 | 660,000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,581,150.0 | 6,685,050.0 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 91,100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 91,100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,038,800.0 | 13,791,000.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 440,000.0 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,598,800.0 | 13,791,000.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 196,000.0 | 1,300,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 196,000.0 | 1,300,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,840,000.0 | 4,783,930.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,630,000.0 | 1,999,800.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 864,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.0 | 1,900,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 30,000.0 | 20,130.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,639,893.4 | 25,449,074.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 610,000.0 | 1,592,000.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,029,893.4 | 23,857,074.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,480,038.0 | 66,789,342.9 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,658,600.0 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 2,933,200.0 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,375,400.0 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 350,000.0 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 62,987,477.8 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | - | 62,987,477.8 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 821,438.0 | 3,801,865.1 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 821,438.0 | 3,801,865.1 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **31,553,912.2** | **(2,913,947.5)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 10,867,736.0 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 10,867,736.0 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (10,867,736.0) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **31,553,912.2** | **(13,781,683.5)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 278,204,230.3 | 27,455,099.2 | 309,584,623.6 | 615,243,953.1 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **278,204,230.3** | **27,455,099.2** | **309,584,623.6** | 615,243,953.1 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 16,937,500.0 | - | - | 16,937,500.0 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 31,553,912.2 | 31,553,912.2 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **295,141,730.3** | **27,455,099.2** | **341,138,535.8** | 663,735,365.3 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **295,141,730.3** | **27,455,099.2** | **341,138,535.8** | 663,735,365.3 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **295,141,730.3** | **27,455,099.2** | **341,138,535.8** | 663,735,365.3 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (13,781,683.5) | (13,781,683.5) |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **295,141,730.3** | **27,455,099.2** | **327,356,852.3** | 649,953,681.8 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **224,654,975.7** | **355,693,130.7** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,370,000.0** | **1,800,000.0** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,370,000.0 | 1,800,000.0 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,370,000.0 | 1,800,000.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 760,000.0 | 1,800,000.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 610,000.0 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **223,284,975.7** | **353,893,130.7** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 190,598,675.7 | 304,724,530.7 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 190,598,675.7 | 304,724,530.7 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,686,300.0 | 49,168,600.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,686,300.0 | 49,168,600.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **195,694,120.2** | **374,296,486.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **195,694,120.2** | **374,296,486.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **185,848,082.2** | **305,722,443.4** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 125,706,555.0 | 213,792,698.8 |
| 210101 | Үндсэн цалин | 93,393,653.4 | 133,581,475.5 |
| 210102 | Нэмэгдэл | 16,894,700.0 | 61,353,003.6 |
| 210104 | Урамшуулал | 15,418,201.6 | 18,858,219.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 15,419,240.8 | 27,005,379.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,574,440.7 | 18,190,392.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,251,086.7 | 2,068,338.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,001,029.3 | 1,356,541.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 223,537.1 | 1,132,842.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,369,147.1 | 4,257,264.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,864,862.0 | 28,866,734.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,984,862.0 | 2,616,734.9 |
| 210302 | Түлш, халаалт | 19,880,000.0 | 26,250,000.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,703,524.3 | 4,487,000.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 300,000.0 | 600,000.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,128,750.0 | 1,950,000.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 724,774.3 | 937,000.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 50,000.0 | 500,000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.0 | 500,000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 500,000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 500,000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,123,800.0 | 16,841,700.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,123,800.0 | 341,700.0 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.0 | 16,500,000.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 196,000.0 | 1,300,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 196,000.0 | 1,300,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,196,400.0 | 10,928,930.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,986,400.0 | 8,858,800.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 150,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.0 | 1,900,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 30,000.0 | 20,130.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,637,700.0 | 2,000,000.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,637,700.0 | 2,000,000.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,846,038.0** | **68,574,042.9** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,024,600.0 | 1,784,700.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 1,004,700.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 2,933,200.0 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,375,400.0 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 716,000.0 | 780,000.0 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 62,987,477.8 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | - | 62,987,477.8 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 821,438.0 | 3,801,865.1 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 821,438.0 | 3,801,865.1 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **28,960,855.6** | **(18,603,355.6)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,019,900.0** | **8,337,600.0** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,019,900.0** | **8,337,600.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,019,900.0 | 8,337,600.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,019,900.0 | 8,337,600.0 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,019,900.0)** | **(8,337,600.0)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 26,940,955.6 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 26,940,955.6 | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Улсын төсвийн гүйцэтгэл:**

***/Төгрөгөөр/***

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 26,940,955.56 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **306,524,600.0** | **270,478,008.5** | **36,046,591.5** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА** | **306,524,600.0** | **270,478,008.5** | **36,046,591.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **306,524,600.0** | **270,478,008.5** | **36,046,591.5** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **304,739,900.0** | **268,693,308.5** | **36,046,591.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **245,200,900.0** | **213,792,698.8** | **31,408,201.2** |
| 210101 | Үндсэн цалин | 149,282,100.0 | 133,581,475.5 | 15,700,624.5 |
| 210102 | Нэмэгдэл | 76,803,900.0 | 61,353,003.6 | 15,450,896.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 19,114,900.0 | 18,858,219.7 | 256,680.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **30,650,200.0** | **27,005,379.7** | **3,644,820.3** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,842,100.0 | 18,190,392.6 | 2,651,707.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,452,000.0 | 2,068,338.4 | 383,661.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,226,000.0 | 1,356,541.4 | (130,541.4) |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,226,000.0 | 1,132,842.8 | 93,157.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,904,100.0 | 4,257,264.5 | 646,835.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,050,000.0** | **5,487,000.0** | **563,000.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 600,000.0 | 600,000.0 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,950,000.0 | 1,950,000.0 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.0 | 937,000.0 | 563,000.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.0 | 1,000,000.0 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.0 | 500,000.0 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.0 | 500,000.0 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **500,000.0** | **500,000.0** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.0 | 500,000.0 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,679,300.0** | **7,679,300.0** | **-** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,679,300.0 | 7,679,300.0 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,300,000.0** | **1,300,000.0** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,300,000.0 | 1,300,000.0 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,359,500.0** | **10,928,930.0** | **430,570.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,859,500.0 | 8,858,800.0 | 700.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.0 | 150,000.0 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,320,000.0 | 1,900,000.0 | 420,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 30,000.0 | 20,130.0 | 9,870.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,000,000.0** | **2,000,000.0** | **-** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.0 | 2,000,000.0 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,784,700.0** | **1,784,700.0** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,784,700.0** | **1,784,700.0** | **-** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,004,700.0 | 1,004,700.0 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 780,000.0 | 780,000.0 | - |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **306,524,600.0** | **306,524,530.7** | **69.3** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 304,724,600.0 | 304,724,530.7 | 69.3 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 1,800,000.0 | 1,800,000.0 | |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **49,168,600.0** | **45,366,734.9** | **3,801,865.1** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА** | **49,168,600.0** | **45,366,734.9** | **3,801,865.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **49,168,600.0** | **45,366,734.9** | **3,801,865.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **49,168,600.0** | **45,366,734.9** | **3,801,865.1** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **32,668,600.0** | **28,866,734.9** | **3,801,865.1** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,418,600.0 | 2,616,734.9 | 3,801,865.1 |
| 210302 | Түлш, халаалт | 26,250,000.0 | 26,250,000.0 | 0.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.0 | 0.0 | 0.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **16,500,000.0** | **16,500,000.0** | **0.0** |
| 210604 | Урсгал засвар | 16,500,000.0 | 16,500,000.0 | 0.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 49,168,600.0 | 45,366,734.9 | 3,801,865.1 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 49,168,600.0 | 45,366,734.9 | 3,801,865.1 |

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 30,218.2 мянган төгрөгийн 6 зөрчилд 6 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Соёлын төвийн дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт хүргүүлсэн.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* 2023 онд худалдан авсан уурын зуухны тээврийн зардал болон ажлын хөлсний зардал 900.0 мянган төгрөгийг Алаг-эрдэнэ сумын Соёлын төвийн даргын 2024.02.16-ны өдрийн А/01 тушаалын дагуу 2024 оны 2 дугаар сарын 16-ны өдөр шилжүүлсэн, уг зардал нь 2023 оны жилийн эцсийн тайланд өглөгөөр тусгаагүй, хөрөнгийн өртөгт тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3-т "*бүх өр төлбөр*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө*", СС-ын 2023 оны 299-р тушаалаар батлагдсан журмын 10.11-т "*Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжих ба өртөг нь хөнгөлөлт, буцаалтыг хассан худалдан авалтын үнэ, түүнийг бэлтгэхтэй холбоотой гарсан тээврийн зардал, гаалийн татвар, хураамж, угсарч суурилуулах, ачиж буулгах гэх мэт шууд хамаарах зардлуудаас бүрдэнэ.*" гэсэн заалтуудыг зөрчсөн, Тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Цаашид ажил гүйлгээ, үйл явдлыг зөв тайлант хугацаанд бүртгэж ажиллах.

*Илрүүлэлт:* Хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооллогын комиссын илтгэх хуудас байхгүй, тооцоо бодсон актгүй, эд хариуцагчдын картад гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооллогын үр дүнг хэлэлцэж шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "*комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх*;" гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Хөрөнгийн тооллогыг өмч хамгаалах комиссын хурлаар хэлэлцүүлж, илтгэх хуудсаар баталгаажуулж байх

*Илрүүлэлт:* Өрнүүн Марал цогт ХХК-руу шилжүүлсэн 2,000.0 мянган төгрөгийн гүйлгээ нь и-баримтаар баталгаажаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*" гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ажил гүйлгээг бүртгэхдээ анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, и-баримтаар баталгаажуулж байх.

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 21 нэр төрлийн 27,318.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлийн 7.1-т "*Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн*

*өмчийн бодлого зохицуулалтын газарт иргүүлж шийдвэрлүүлнэ*" гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр шийдвэрлэх

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Шилэн дансны тайланд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар оруулж хэвшээгүй, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:" гэж заасан заалтуудтай нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь, иж бүрэн мэдээлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

*Илрүүлэлт*: Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Соёлын төв нь ахмадын сан байгуулаагүй, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасанд нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Ахмад настны тухай хуульд заасны дагуу Ахмадын сан байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмнөх тайлант хугацааны өр төлбөрийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрсөн | 1 | 900.0 | | | | | 1 | 900.0 |
| Хөрөнгийн тооллогын үр дүнг хэлэлцээгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| И-Баримтгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн | 1 | 2,000.0 | | | | | 1 | 2,000.0 |
| 0 үлдэгдэлтэй хөрөнгө шийдвэрлээгүй | 1 | 27,318.2 | | | | | 1 | 27,318.2 |
| Дүн | 4 | 30,218.2 | | | | | 4 | 30,218.2 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны мэдээлэл дутуу оруулсан | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Ахмадын сан байгуулаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | **2** | **0** | | | | | **2** | **0** |